



ДОРНОД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Гадаадын иргэн, харьяатын газрын зүүн бүс дэх газрын 2019 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: ДОА-2020/74/СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: www.audit.mn Дорнод аймаг 2020 он</p>	<p>Дорнод аймаг дахь Төрийн аудитын газрын дарга бөгөөд Тэргүүлэх аудитор: Б.Болортуул Утас: 70584203 Цахим хаяг: Bolortuulb@audit.gov.mn Аудитын менежер: В.Цэнгэлмаа Утас: 70584204 Цахим хаяг: Tsengelmaav@audit.gov.mn Аудитор: М.Ухаанбилэг Утас: 70584207 Цахим хаяг: Ukhaanbilegm@audit.gov.mn</p>
--	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
ДОА	Дорнод аймаг
СТА	Санхүүгийн тайлангийн аудит
ТШЗ	Төсвийн шууд захирагч
ГИХГ	Гадаадын иргэн, харьяатын газар



Аудитын гэрчилгээ	3
Аудитын тайлан	5
2.1. Оршил.....	5
2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага	5
2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт	5
2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин.....	6
2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ.....	6
2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал	6
2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар	6
2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд	6
2.9. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга	7
2.10. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн.....	7
2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал.....	8
2.12. Шилэн дансны мэдээлэл.....	9
2.13. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт	9
2.14. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл	9
Менежментийн захидал	10
Аудит хийгдсэн санхүүгийн тайлан	11
1.1 Аудит хийгдсэн санхүүгийн байдлын тайлан	113
4.2 Аудит хийгдсэн санхүүгийн үр дүнгийн тайлан.....	124
4.3 Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	135
4.4 Аудит хийгдсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	156
4.5 Аудит хийгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	157





2.1. Оршил

Гадаадын иргэн, харьяатын газрын зүүн бүс дэх газрын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг дарга Б.Тамир танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц асуудал, залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил, тодруулга зэрэг аудитын үр дүн, аудитын дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Гадаадын иргэн, харьяатын газрын зүүн бүс дэх газрын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Гадаадын иргэн, харьяатын газрын зүүн бүс дэх газрын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2020 оны 02 дугаар сарын 12-ноос 2020 оны 02 дугаар сарын 14-ний хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2020 оны 02 дугаар сарын 18-ны өдөр эцэслэн баталгаажуулж, төсвийн шууд захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, аудитор М.Ухаанбилэг хариуцаж хэрэгжүүлэв.

Гадаадын иргэн, харьяатын газрын зүүн бүс дэх газрын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Дорнод аймаг дахь Төрийн аудитын газарт 2020 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн 12/13 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайлангийн аудитад баримтлах ерөнхий чиглэл, арга зүйг мөрдөн ажиллав.

Дээрх стандарт, зарчим, журамд нийцүүлж аудитын үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Гадаадын иргэн, харьяатын газрын зүүн бүс дэх газар нь “Хүний эрх, эрх чөлөө, үндэсний эрх ашгийг дээдэлж, олон улсын жишигт нийцсэн нээлттэй, хариуцлагатай үйл ажиллагааг явуулах” гэсэн эрхэм зорилгыг хүрээнд ажиллаж байна.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд өөрчлөлт ороогүй байна.

2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа, дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан болно.

Тус мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь Сангийн яамнаас хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Гадаадын иргэн, харьяатын газрын зүүн бүс дэх газар нь санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд Unicus программ хангамж ашигладаг байна.

Гадаадын иргэн, харьяатын газрын зүүн бүс дэх газрын дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй байна.

2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитаар Гадаадын иргэн, харьяатын газрын зүүн бүс дэх газрын бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судлан, эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэллээ.

Аудитын төлөвлөлтийн үе шатанд 18 эрсдэлтэй асуудалд горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2018 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн нийт зардлыг сонгож, эрсдэлийн түвшинг “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд сонгосон суурь үзүүлэлтийн дүн 574,743.7 мянган төгрөгөөс тооцон 11,494.8 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшинг өсгөн 12,239.7 мянган төгрөгөөр тооцсон болно.

2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд

Гадаадын иргэн, харьяатын газрын зүүн бүс дэх газрын 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 558,411.9 мянган төгрөгөөр буюу 65,2 хувиар өссөн байна. Материаллаг хэмжээний өөрчлөлт орсон үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	0.0	0.0	0.0
Авлага	0.0	0.0	0.0
Урьдчилгаа	0.0	0.0	0.0
Бараа материал	70,357.3	58,259.1	-12,098.2
Үндсэн хөрөнгө	498,126.4	1,145,136.1	647,009.7
Элэгдэл	-192,602.4	-269,102.0	-76,499.5
Нийт хөрөнгө	375,881.3	931,739.2	558,411.9
Өр төлбөр	0.0	0.0	0.0
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	375,881.3	931,739.0	558,411.9
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	375,881.3	931,739.0	558,411.9

Бараа материалын дансны үлдэгдэл өмнө оноос буурсан нь бараа материал акталсан дүнгээр буурсан байна .

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл өссөн нь хөрөнгө оруулалтаас шалтгаалжээ. Энэ нь Төрийн өмчийн хорооны тогтоолоор приус автомашин 12,500.0 мянган, палкан барилга 7,000.0 мянган төгрөг, конторын барилга 600,000.0 мянган төгрөг, ГИХГ-аас өгсөн 38 ширхэг 27,509.7 мянган төгрөгийн тоног төхөөрөмжүүдийн дүнгээр өссөн байна.

2.9. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

ГИХГ-ын Зүүн бүс дэх газар нь орлого төвлөрүүлдэггүй тул орлогын төлөвлөгөө батлаагүй байна.

Тайлант онд Төсвийн шууд захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрт зориулан үндсэн үйл ажиллагаанд 512,741.9 мянган төгрөгийн төсөв батлагдсан нь урсгал зардалд зарцуулахаар батлагджээ.

Нийт зардлын 512,741.9 мянган төгрөгийг улсын төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 4.5-д харуулав.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 505,984.8 мянган төгрөг буюу 98,6 хувьтай байна.

Нэмэлт төсөв: Дээд шатны төсвийн захирагчаас газар чөлөөлөх, хашаа сэлгэхэд зориулж 5,000.0 мянган төгрөгийг нэмэлт төсөвт хуваарилсан байна.

Үүнийг урсгал засварын зардалд хуваарилан хашаа сэлгэх, газар чөлөөлөхөд зарцуулсан байна.

2.10. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон 18 эрсдэл, гүйцэтгэх үе шатанд 18 эрсдэл тодорхойлж нийт 18 горим сорил хэрэгжүүллээ.

Аудитаар нийт 40,439.1 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс, 2,554.2 мянган төгрөгийн алдааг залруулж, 29,642.8 мянган төгрөгийн зөрчилд 1 албан шаардлага, 6,414.3

мянган төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн акт тогтоож, 1,827.8 мянган төгрөгийн алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 1 зөвлөмж өглөө.

Аудитаар дараах 37,881.7 мянган төгрөгийн залруулагдаагүй алдаа, зөрчил илэрснээс 6,414.3 мянган төгрөгийн зөрчилд төлбөрийн акт, 29,642.8 мянган төгрөгийн зөрчилд албан шаардлага хүргүүлээ. Үүнд:

1. Шатахуунаас 1,879.2 мянган төгрөгийн үлдэгдлийг нөөцлөн авч он дамжуулан зарцуулж байгаа нь Төсвийн тухай хуулийн 43.5 дахь “Төсвийн захирагч нь энэ хуулийн 43.1.3, 43.1.5-д зааснаас бусад төсвийг хоёр төсвийн жил дамжуулан зарцуулахгүй.” гэсэн заалттай нийцэхгүй, үнэн зөв байдал гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн акт тогтоох

2. Тайлант онд Тарийн тусгай албан тушаалд ажиллаж байгаад өндөр насны тэтгэвэр тогтоолгосон иргэнийг авч ажиллуулахдаа 4,535.1 мянган төгрөгийн төрийн албан хаасан хугацааны нэмэгдэл, мэргэжлийн зэргийн нэмэгдлүүдийг олгосон байна. Энэ нь Төрийн албаны тухай хуулийн 57 дугаар зүйлийн 57.2.3 дахь хэсэгт заасан түүний тэтгэвэрт гарахаас өмнө урд ажилласан жилүүдэд хамаарах ажлын үр дүнг тооцон төрийн алба хаасан хугацааны нэмэгдэл болон ажилласан хугацаанаас хамааруулан олгодог зэрэг, дэвийн нэмэгдлийг дахин сэргээж олгох үндэслэл болохгүй юм. Харин төрийн тусгай албан хаагч төрийн алба хаах насны дээд хязгаар хүртэл төрийн байгууллагад энгийн албан тушаалд томилогдон ажиллах боломжтой юм. Иймээс санхүүгийн тайлангийн аудитын үнэн зөв байдал гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн акт тогтоох

3. Тайлант хугацаанд хийсэн худалдан авалтын Е баримтыг анхан шатны баримтад бүрэн хавсаргаагүй, татварын ебаримт программд 29,642.8 мянган төгрөгийн худалдан авалт бүртгэгдээгүй, Мөн Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 3.1.3 дахь “анхан шатны баримт гэж, төлбөр төлсөн баримт болон бусад нотолгоог”, 13.4 дэх “Аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, нягтлан бодогч нь үйлдвэрлэл, үйлчилгээний шат дамжлага, аж ахуйн үйл ажиллагааны хүрээнд гарсан хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл, өөрчлөлт бүрийг анхан шатны баримтад бичгээр болон цахимаар бичилт хийж баталгаажуулна”, Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаалаар батлагдсан “Өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж, байгууллагад нийтлэг хэрэглэгдэх анхан шатны бүртгэлийн маягтыг нөхөх заавар”-ын 6.5 дахь Монгол Улсын стандарт MNS 6529:2015 “татварын нэгдсэн системд ашиглах төлбөрийн баримтын ерөнхий шаардлага”-тай тус тус нийцэхгүй, үнэн зөв байдал, тохиолдсон байх, иж бүрэн байх гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага өгөх

Аудитаар илэрсэн 1,827.8 мянган төгрөгийн алдаа, зөрчилд 1 зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгалаа.

2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Анхаарал татахуйц асуудал байхгүй байна.



2.12. Шилэн дансны мэдээлэл

Гадаадын иргэн, харьяатын газрын зүүн бүс дэх газар нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллүүдээс хугацаа хоцроосон болон оруулаагүй мэдээлэл байхгүй байна.

2.13. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 450,0 мянган төгрөгийн төлбөрийн акт тогтоогдсоныг бүрэн барагдуулж ажилласан байна.

2.14. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Гадаадын иргэн, харьяатын газрын зүүн бүс дэх газрын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

“Зөрчилгүй” дүгнэлт

Гадаадын иргэн, харьяатын газрын зүүн бүс дэх газрын 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлт болон бусад илчлэл тодруулгыг НББ-ийн тухай хуулийн 4.1.3, УСНББОУС-ын дагуу материаллаг байдлын хувьд үнэн зөв, бодитой илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын **агуулга аудитын үр дүн, дүгнэлтээс** урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

1. Бараа материалын данстай холбоотой асуудал

1.1. Илрүүлэлт:

Шатахуун зарцуулалтыг анхан шатны баримттай тулган үзэхэд дуудлагын автомашиныг албан ажлаар бус хот дотор 1827,8 мянган төгрөгийн шатахуун зарцуулсан байна. Энэ нь Засгийн газрын 2015 оны 184 дүгээр тогтоолтой нийцэхгүй байна.

1.2. Эрсдэл:

Зориулалт бусаар зарцуулагдах

1.3. Өгсөн зөвлөмж:

Засгийн газрын 2015 оны 184 дүгээр тогтоолыг мөрдөж ажиллах

1.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2020 оны 04 дүгээр сарын 25-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

Аудит хийгдсэн санхүүгийн тайлан

1.1 Аудит хийгдсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>70357388.40</u>	<u>58259147.20</u>
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	0.00	0.00
35	БАРАА МАТЕРИАЛ	70357388.40	58259147.20
354	Хангамжийн материал	70357388.40	58259147.20
35410	Бичиг хэргийн материал	1958632.00	1916780.00
35420	Аж ахуйн материал	18370424.90	8685880.00
35440	Тулш, шатах тослох материал	2865000.00	6490270.00
35470	Бусад хангамжийн материал	47163331.50	41166217.20
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>305523958.64</u>	<u>873479913.58</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	305523958.64	873479913.58
392	Биет хөрөнгө	303578333.79	872077413.58
39201	Барилга, байгууламж, орон сууц	129637739.35	736637739.35
39202	Хуримтлагдсан элэгдэл	-5623100.06	-9993373.36
39203	Авто-тээврийн хэрэгсэл	229000000.00	241500000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-90940590.61	-132975312.88
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	110101751.89	137611454.89
39206	Хуримтлагдсан элэгдэл	-78860582.04	-108697291.35
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	26636930.00	26636930.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	-16373814.74	-18642733.07
393	Биет бус хөрөнгө	1945624.85	1402500.00
39301	Програм хангамж	2750000.00	2750000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-804375.15	-1347500.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>375881347.04</u>	<u>931739060.78</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	<u>0.00</u>	<u>0.00</u>
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	0.00	0.00
42	УРТ ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	0.00	0.00
421	Урт хугацаат үнэт цаас	0.00	0.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>375881347.04</u>	<u>931739060.78</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	375881347.04	931739060.78
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	0.00	0.00
512	Хуримтлагдсан үр дүн	369372292.17	925230005.91
51210	Өмнөх үеийн үр дүн	369372292.17	369372292.17
51220	Тайлант үеийн үр дүн	0.00	555857713.74
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	6509054.87	6509054.87
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>375881347.04</u>	<u>931739060.78</u>



4.2 Аудит хийгдсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	556255794.63	1167844674.70
11	ТАТВАРЫН ОРЛОГО	0.00	0.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	41127394.63	650102774.70
120	Нийтлэг татварын бус орлого	41127394.63	650102774.70
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	41127394.63	650102774.70
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	41127394.63	650102774.70
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	515128400.00	517741900.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	515128400.00	512741900.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	515128400.00	512741900.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	0.00	5000000.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	0.00	5000000.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	574743761.34	611986960.96
21	УРСГАЛ ЗАРДАЛ	574743761.34	611986960.96
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	528743902.09	603235111.40
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	327701080.19	349022031.86
210101	Үндсэн цалин	223366780.19	231155231.86
210102	Нэмэгдэл	66054300.00	77586800.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	38280000.00	40280000.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	38517190.97	44089523.12
210201	Тэтгэврийн даатгал	24756390.97	29834923.12
210202	Тэтгэмжийн даатгал	3440200.00	3563100.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	2752200.00	2850700.00
210204	Ажилгүйдлийн даатгал	688000.00	713500.00
210205	Эрүүл мэндийн даатгал	6880400.00	7127300.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	17424586.00	18381647.50
210301	Гэрэл, цахилгаан	7241172.00	9015784.50
210302	Түлш, халаалт	7267176.00	8423213.00
210303	Цэвэр, бохир ус	422738.00	810650.00
210304	Байрны түрээс	2493500.00	132000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	47007978.59	60139549.86
210401	Бичиг хэрэг	4048646.00	4771502.00
210402	Тээвэр, шатахуун	31629200.00	27120730.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2949782.59	2707610.96
210404	Ном, хэвлэл	81600.00	100000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	8298750.00	4817182.00
210408	Бараа материал акталсны зардал	0.00	20622524.90
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	14075680.00	35476359.00
210604	Урсгал засвар	14075680.00	35476359.00
2107	Томилолт, зочны зардал	3209250.00	3755800.00
210702	Дотоод албан томилолт	3209250.00	3755800.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	10448151.00	12721446.00



210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	3091000.00	1065290.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	0.00	360000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	151051.00	149056.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	44000.00	44000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	524900.00	2333500.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	6637200.00	8769600.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	70359985.34	79648754.06
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	8183000.00	6391820.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	4501670.00	1526900.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	57675315.34	71730034.06
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	45999859.25	8751849.56
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	0.00	0.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	3670200.00	1994781.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	3670200.00	1994781.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	42329659.25	6757068.56
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	42329659.25	6757068.56
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	-18487966.71	555857713.74
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	0.00	0.00
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	-18487966.71	555857713.74

4.3 Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	515128400.00	517741900.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	515128400.00	517741900.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	515128400.00	512741900.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	515128400.00	512741900.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	0.00	5000000.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	0.00	5000000.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	515128400.00	517741900.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	515128400.00	517741900.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	469128540.75	508990050.44
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	327701080.19	349022031.86
210101	Үндсэн цалин	223366780.19	231155231.86
210102	Нэмэгдэл	66054300.00	77586800.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	38280000.00	40280000.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	38517190.97	44089523.12
210201	Тэтгэврийн даатгал	24756390.97	29834923.12



210202	Тэтгэмжийн даатгал	3440200.00	3563100.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	2752200.00	2850700.00
210204	Ажилгүйдлийн даатгал	688000.00	713500.00
210205	Эрүүл мэндийн даатгал	6880400.00	7127300.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	18604586.00	20127647.50
210301	Гэрэл, цахилгаан	7241172.00	9015784.50
210302	Түлш, халаалт	8447176.00	10169213.00
210303	Цэвэр, бохир ус	422738.00	810650.00
210304	Байрны түрээс	2493500.00	132000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	47853132.59	42375722.96
210401	Бичиг хэрэг	6210000.00	4981650.00
210402	Тээвэр, шатахуун	31629200.00	29000000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2949782.59	2707610.96
210404	Ном, хэвлэл	81600.00	100000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	6982550.00	5586462.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	14075680.00	35476359.00
210604	Урсгал засвар	14075680.00	35476359.00
2107	Томилолт, зочны зардал	3209250.00	3755800.00
210702	Дотоод албан томилолт	3209250.00	3755800.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	4285951.00	4611846.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	3091000.00	1065290.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	0.00	360000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	151051.00	149056.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	44000.00	44000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	999900.00	2993500.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	14881670.00	9531120.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	10015000.00	8004220.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	4866670.00	1526900.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	45999859.25	8751849.56
2132	Бусад урсгал шилжүүлэг	3670200.00	1994781.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	3670200.00	1994781.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	42329659.25	6757068.56
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	42329659.25	6757068.56
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	0.00	0.00
	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	0.00	0.00
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	0.00	0.00
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.00	0.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.00	0.00

4.4 Аудит хийгдсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	0.00	6,509,054.87	369,372,292.17	375,881,347.04
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	0.00	0.00
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	0.00	6,509,054.87	369,372,292.17	375,881,347.04
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	0.00	0.00	0.00	0.00
Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	0.00	0.00	0.00	0.00
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0.00	0.00	0.00	0.00
Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү				0.00
Тайлант үеийн үр дүн			555,857,713.74	555,857,713.74
2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	0.00	6,509,054.87	925,230,005.91	931,739,060.78

4.5 Аудит хийгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	512741900.00	510984831.44
21	УРСГАЛ ЗАРДАЛ	512741900.00	510984831.44
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	510741900.00	508990050.44
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	350339200.00	349022031.86
210101	Үндсэн цалин	232472400.00	231155231.86
210102	Нэмэгдэл	77586800.00	77586800.00



210103	Унаа хоолны хөнгөлөлт	40280000.00	40280000.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	45613200.00	44089523.12
210201	Тэтгэврийн даатгал	31358600.00	29834923.12
210202	Тэтгэмжийн даатгал	3563100.00	3563100.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	2850700.00	2850700.00
210204	Ажилгүйдлийн даатгал	713500.00	713500.00
210205	Эрүүл мэндийн даатгал	7127300.00	7127300.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	23160500.00	20127647.50
210301	Гэрэл, цахилгаан	10043200.00	9015784.50
210302	Түлш, халаалт	10185300.00	10169213.00
210303	Цэвэр, бохир ус	2782000.00	810650.00
210304	Байрны түрээс	150000.00	132000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	42577300.00	42375722.96
210401	Бичиг хэрэг	4988600.00	4981650.00
210402	Тээвэр, шатахуун	29000000.00	29000000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2901400.00	2707610.96
210404	Ном, хэвлэл	100000.00	100000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	5587300.00	5586462.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	30477800.00	35476359.00
210604	Урсгал засвар	30477800.00	35476359.00
2107	Томилолт, зочны зардал	3759000.00	3755800.00
210702	Дотоод албан томилолт	3759000.00	3755800.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	5230300.00	4611846.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1676000.00	1065290.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	360000.00	360000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	149100.00	149056.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	45200.00	44000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	3000000.00	2993500.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	9584600.00	9531120.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	8015000.00	8004220.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1569600.00	1526900.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	2000000.00	1994781.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	2000000.00	1994781.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	2000000.00	1994781.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	512741900.00	512741900.00
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	512741900.00	512741900.00
131001	Улсын төсвөөс санхүүжих	512741900.00	512741900.00
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	0.00	0.00
1340	НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	0.00	0.00
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	0.00	0.00
122	ТУСЛАМЖИЙН ЭХ ҮҮСВЭРЭЭС САНХҮҮЖИХ	0.00	0.00
14	БУСАД ЭХ ҮҮСВЭР	0.00	0.00
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		0.00



5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		0.00
6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ		
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	0.00	0.00